

А. АМРЫГ АЙЛТГАЖ, МЭНДИЙГ МЭДЭХ ЁС

1. ЕРӨӨЛТ МЭНД



Зургийг ажиглаарай. Хүмүүс юу хийж байна вэ?



1



2



3



Дээрх нөхцөлд ерөөлт мэндийн ямар үгс тохирох вэ? Бэлгэ дэмбэрэлтэй мэндийн ард тохирох зургийн дугаарыг бичээрэй.

Саасан сүү нь сав дүүрэг
Санасан хэрэг нь
сэтгэлчлэн бүтэг!

Үйл уран болог!

Авсандаа ачтай
Өгсөндөө өлзийтэй болог!



Монголчууд айлд ирэх, өөр зуураа уулзахдаа ямар нэг ажил, үйл хийж байхад нь таарвал ерөөлтэй сайхан мэндийн үг хэлнэ. Энэ нь ажил үйлс нь бүтэмжтэй сайхан байхыг бэлгэддэг. Ерөөлт мэндийн хариуд

- Ерөөл бат оршиг!
- Ерөөлөөр болог!
- Ерөөл тогтог! хэмээн хариулна.



Зургийг тохирох ерөөлт мэндийн үгтэй холбоорой.



○

○

Хөрөө хурц болог!



○

○

Ургац арвин болтугай!



○

○

Мэдлэгээ нэмж
Мэргэн болоорой!



Дараах тохиолдолд ямар ерөөлт мэнд хэлж болох вэ? Зохиож бичээрэй.

- Хонио ноосолж буй хүнд
- Хоол хийж буй хүнд
- Цахим сүлжээнд мэдээлэл хайж буй хүнд
- Зураг зурж буй хүнд

Монголчууд бид “Амны бэлгээс ашдын бэлгэ” хэмээн хэлэлцдэг. Ажил үйл нь бүтэхийг ерөөн бие биедээ урам хайрлаж, сайн сайхныг бэлгэшээдэг монгол уламжлалаа хэвшүүлцгээе.



Дараах нөхцөлд ерөөлт мэндийн ямар үг хэлэх вэ? Тохирох үгийг олж мэдээд бичээрэй.

- Шинэ хувцас өмсөж буй хүнд
- Шинэ зүйл урлан бүтээж буй хүнд
- Ногоо тарьж буй хүнд
- Хадлан хадаж буй хүнд

ЕРӨӨЛИЙН ҮЗҮҮРТ ТОС

2. ЭРДЭМ ГЭЖ ЮУ ВЭ?



Гэртээ болон хичээл дээр хамгийн сайн хийж чаддаг зүйл чинь юу вэ?



Эрдэм гэж чухам юу болохыг
Ээжээс би сонирхон асуув
Тустай бүхэн эрдэм гэж
Тухлан байж ээж хэлэхдээ:

Мал маллаж сурсан ч эрдэм
Машин жолоодож сурсан ч эрдэм
Ном бичиг сурсан ч эрдэм
Ногоо тарьж сурсан ч эрдэм
Хоол хийж сурсан ч эрдэм
Хог арилгаж сурсан ч эрдэм
Тэр бүхнийг сурах эсэхийг
Тэвчээр, зориг хоёр мэднэ.

Хойш сууж залхуурсан хүн л
Хорвоогийн эрдмээс хоцорно гэв

М.Хуушаан



Эрдэм гэж юу вэ? Чи юу гэж бодож байна вэ? Ээжийн хэлсэнтэй санал нийлж байна уу?



Дараах хүмүүсийн сурсан эрдэм юу вэ? Мэддэгээ жагсаан бичээрэй.



Багш

.....
.....



Малчин

.....
.....



Сувилагч

.....
.....



Цагдаа

.....
.....



Чи ямар эрдэмтэй вэ? Нэмж бичиж болно.

Ном уншиж сурсан. Тоо бодож сурсан.

Морь унаж сурсан.

Бичиж сурсан. Дуу дуулж сурсан. Бүжиг бүжиглэж сурсан.

Дасгал хийж сурсан. Үнээ сааж сурсан.



Дараах үйлдлүүд эрдэм мөн үү?

- Бусдад бялдуучлах
- Уран яруу ярих
- Бусдын өмнүүр орж, өөрөө түрүүлж хүртэх
- Уучлал гуйх



Дараах зүйр цэцэн үгийн утгыг хамтдаа тайлбарлаарай.

Эдийн ашиг эхэндээ
Эрдмийн ашиг эцэстээ

3. ХЭЦҮҮ БОДЛОГЫН ХАРИУГ ЗҮҮДЭНДЭЭ БОДДОГ ХҮҮ



Хамгийн сайхан зүүдээ санаарай. Найзууддаа ярьж өгөөрэй.



М.Лханаажав хүү тоо бодох тун дуртай. Тэр гуравдугаар ангид байхдаа нэгэн өглөө “Эж ээ, дараалсан гурван тооны нийлбэр үнэхээр гуравт хуваагддаг юм байна” гэсээр сэржээ.

Багш нь тоо бодох сонирхлыг нь улам төрүүлж, түүнд их нөлөөлжээ. Найзуудтайгаа уралдан тоо бодож, учрыг нь олж, хариуг гаргах үедээ тэр өөртөө бүр их итгэлтэй болдог байв.

Лханаажав дэлхийн хэмжээний математикч болно гэсэн зорилго тавин цаг, минут бүрийг тоо бодоход зориулж, уйгагүй зүтгэсээр санасандаа хүрчээ. Тэрээр сургуулиа төгсөх жилээ Дэлхийн математикийн олимпиадаас мөнгөн медаль авав. Энэхүү амжилтынх нь нууцыг асуусан үе тэнгийнхэндээ тэр дараах үгийг үргэлж хэлдэг.



“Цаг хугацаатай уралдан, хичээж зүтгэснийхээ ач тусыг хүртэнэ гэдэг маш сайхан мэдрэмж. Дуртай зүйлээ хийж байгаа хүнээс хичээл зүтгэл, хөдөлмөр аяндаа гардаг. Оролдож үзээгүй байж чадахгүй гэж хэзээ ч бүү хэлж байгаарай. Сурсан бүхэн мөрөөдөлд хүрэх гишгүүр болдог юм шүү.”



Хүүгийн сурсан эрдмийг эхээс олж, доогуур нь зураарай.




Асуултын дагуу ярилцаарай.

- Хүүг мөрөөдөлдөө хүрэхэд юу тусалсан бэ?
- Чиний мөрөөдөл юу вэ? Мөрөөдөлдөө хүрэхийн тулд юу сурах хэрэгтэй вэ?



Бодлын туршилт: Оюуны зураглал хийж, бодлоо цэгцлээрэй.



4. ШИДЭТ ДҮРС



Хүсэл мөрөөдлөө биелүүлэхэд чинь шидэт дүрс чамд тусална. Дараах төлөвлөгөөтэй танилцаад, өөрийн төлөвлөгөөг зохиогоорой.

Гадаад хэл сурна.	Долоо хоногт нэг ном уншина.	Өдөр бүр бусадтай мэндэлнэ.	Багшдаа талархлын үг хэлж хэвшинэ.
Алдаагүй бичих дасгал хийнэ.	1.Өөрөө бие даан сурна.	2.Бусадтай харилцана.	Олон найзтай болно.
Би чадна гэж дандаа бодно.	3.Өөртөө үргэлж итгэнэ.	Манлайлагч болно.	Байнга инээмсэглэнэ.
Илтгэлээ урьдчилан ярьж, бэлдэнэ.	Хийснээ байнга хянана.	Шатрын дугуйланд явна.	Мөнгө цуглуулна.

Захирал болно.



Төлөвлөгөө хэрхэн зохиох вэ?

1. Мөрөөдлөө бичнэ.
2. Зорилгуудаа эмхлэн жагсаана.
3. Зорилго тус бүрийг биелүүлэхэд шаардлагатай алхмуудыг бичнэ.
4. Алхмын дагуу цагаа хуваарилан хэрэгжүүлж эхэлнэ.

Оролдвол бүтнэ
Уралдвал түрүүлнэ



Мөрөөдлөө хүснэгтийн голд бичиж, биелүүлэх төлөвлөгөө зохиогоорой.

алхам 1	алхам 2	алхам 1	алхам 2
алхам 3	1.зорилго	2.зорилго	алхам 3
алхам 1	МӨРӨӨДӨЛ		алхам 1
алхам 2	3.зорилго	4.зорилго	алхам 3
алхам 2	алхам 3	алхам 2	алхам 3



Хагас жил, жилийн дараа төлөвлөгөө тань хэр сайн биелсэн эсэхийг хянаарай. Харахан биелж амжаагүй зорилтоо биелүүлэхийг хичээгээрэй.

5. БҮТЭЭЛЧ ХҮМҮҮС



Чи дараах зүйлсээс аль нэг нь огт байдаггүй гэж төсөөлөөрэй. Тэгвэл амьдрал ямар байх бол?




Бидний амьдралд өөр юу зайлшгүй чухал вэ?



Монгол орон бол адгуусан амьтныг гаршуулж, гэршүүлсэн голомт нутгуудын нэг. 3500 гаруй жилийн өмнө дэлхийн уур амьсгал өөрчлөгдөж, Монгол нутагт эрс тэс, хуурай уур амьсгал давамгайлжээ. Үүний улмаас газар тариалан эрхлэх, эсвэл суурин мал аж ахуй эрхлэх боломж байсангүй. Ингээд хүмүүс цаг агаартаа дасан зохицох аж ахуй эрхлэх болсон нь

нүүдлийн мал ахуй байлаа. Хүмүүс мал сүргээ өсгөн үржүүлэх, арчлах, хариулан маллах, адуу, үхрийг уналга тээвэрт ашиглах аргад суралцан, асар баялаг туршлага хуримтлуулжээ.

Бидний өвөг дээдэс маш бүтээлч хүмүүс байлаа. Одоогийнх шиг үйлдвэр хөгжиж, юм бүхэн бэлэн байгаагүй тул амьдрах гэр орон, тавилга, өмсөж зүүх хувцас хунар, эдлэл хэрэглэл гээд бүх зүйлээ өөрсдөө хийдэг байв. Малынхаа ашиг тусыг талархан хүртэж, аргал, хомоолыг нь ч хаялгүй ашиглаж иржээ.



Асуултад хариулж бичээрэй.

- Монголчууд хэзээнээс нүүдлийн мал аж ахуй эрхлэх болсон бэ?
- Яагаад нүүдлийн мал аж ахуй эрхлэх болсон бэ?
- Нүүдэлчдийн соёл иргэншил гэж юу вэ?



Мал сүргээсээ юу, юуг нь хэрхэн ашигладаг вэ?

Ноос:

Хялгас:

Дэл, сүүл:

Зогдор:

Ноолуур:

Арьс, шир:

Мах:

Эвэр, туурай:

Сүү:

Аргал, хоргол:



Дараах сэдвээр бодлын туршилт хийж, эх зохион бичээрэй.
“Хүн төрөлхтөн хийж бүтээж чаддаггүй байсан бол...”